**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ӨМА-2026/109/НА-СТА-ТШ3

Цахим хуудас: www.audit.mn

Даланзадгад хот

2026 он


Өмнөговь дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Болормаа
Утас: 70533552 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn
Аудитор: Э.Жаргал
Утас: 70533552 Цахим хаяг: jargale@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.02.23 № 64

танай ______________-ны №______________ -т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ОРОН
НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.МӨНГӨНЧИМЭГ ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайланд онд сургалт зохион байгуулахдаа 105,500.0 мянган төгрөгийг цай, хоол, буудлын зардалд зарцуулсан, дотоод албан томилолт олгохдоо албан хаагчидад 1,910.0 мянган төгрөгийн хоолны нөхөх төлбөрийг давхардуулан олгож төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.1, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 19,752,701.4 мянган төгрөгийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэлд тусгасан байна.

4626050060

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Өмнөговь аймгийн хэмжээнд хэрэгжүүлж буй “Нутгийн дэм” хөтөлбөрт байгууллагын ажилтан албан хаагчдыг хамруулж 71,397.2 мянган төгрөг, төрийн үйлчилгээний албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл 43,078.0 мянган төгрөгийг олгосон байна.

**Бусад асуудал хэсэг**

Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 7/17 дугаар тогтоолын дагуу 2,922,727.6 мянган төгрөгийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг баланс хооронд шилжүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

| Балансын зүйл | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | **9,503,794,361.98** | **10,519,444,101.00** |
| МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 4 | - | - |
| Банканд байгаа бэлэн мөнгө | | - | - |
| Төгрөг | | - | - |
| Төрийн сангийн харилцах | | - | - |
| Арилжааны банк дахь харилцах | | - | - |
| АВЛАГА | **5** | **19,799.98** | **1,309,488.00** |
| Ажиллагчидтай холбогдсон авлага | | 19,799.98 | 1,309,499.00 |
| БАРАА МАТЕРИАЛ | 6 | 568,169,756.00 | 784,475,583.00 |
| Хангамжийн материал | | 568,169,756.00 | 784,475,583.00 |
| Бичиг хэргийн материал | | 3,097,500.00 | 4,387,500.00 |
| Аж ахуйн материал | | 503,026,573.00 | 503,026,573.00 |
| Сэлбэг хэрэгсэл | | 357,000.00 | 357,000.00 |
| Түлш, шатах тослох материал | | 3,282,173.00 | - |
| Бусад хангамжийн материал | | 58,406,510.00 | 276,704,510.00 |
| НӨӨЦИЙН БАРАА | | **8,935,604,806.00** | **9,733,659,030.00** |
| Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/ | | 8,935,604,806.00 | 9,733,659,030.00 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | **9,503,794,361.98** | **10,519,444,101.00** |
| ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 7 | 69,549,164,003.42 | 67,665,005,199.32 |
| Биет хөрөнгө | | 67,961,881,420.12 | 66,088,906,945.93 |
| Барилга, байгууламж, орон сууц | | 57,442,420,972.97 | 44,112,104,099.77 |
| Хуримтлагдсан элэгдэл /Барилга, байгууламж, орон сууц | | (744,536,247.12) | (972,162,469.18) |
| Авто-тээврийн хэрэгсэл | | 3,180,926,610.20 | 4,619,234,610.20 |
| Хуримтлагдсан элэгдэл/Авто-тээврийн хэрэгсэл | | (666,674,493.66) | (935,498,211.21) |
| Машин тоног төхөөрөмж (компьютер) | | 996,823,299.00 | 2,198,053,233.38 |
| Хуримтлагдсан элэгдэл | | (110,737,648.24) | (169,422,845.84) |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | | 151,162,476.32 | 432,748,041.08 |
| Хуримтлагдсан элэгдэл | | (27,772,001.48) | (35,084,848.03) |
| Бусад үндсэн хөрөнгө | | 12,583,165,002.00 | 20,223,367,087.98 |
| Хуримтлагдсан элэгдэл | | (482,896,549.87) | (3,384,431,752.22) |
| Биет бус хөрөнгө | | 1,587,282,583.30 | 1,576,098,253.39 |
| Программ хангамж | | 62,336,000.00 | 54,320,000.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | | (30,161,416.70) | (33,329,746.61) |
| Бусад биет бус хөрөнгө | | 1,555,108,000.00 | 1,555,108,000.00 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | **69,549,164,003.42** | **67,665,005,199.32** |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | | **79,052,958,365.40** | **78,184,449,300.32** |
| ӨР ТӨЛБӨР | | **-** | **1,991,765.63** |
| БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | - | 1,991,765.63 |
| Өглөг | 9 | - | 1,791,765.63 |
| Ажилчидтай холбогдсон өглөг | | - | 200,000.00 |
| Бусад өглөг | | - | 200,000.00 |
| Засгийн газрын хувь оролцоо | | 79,052,958,365.40 | 78,182,457,534.69 |
| Хуримтлагдсан үр дүн | | 78,849,037,174.52 | 77,978,536,343.81 |
| Тайлант үеийн үр дүн | | | (870,500,830.71) |
| Өмнөх үеийн үр дүн | | 78,849,037,174.52 | 78,849,037,174.52 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 203,921,190.88 | 203,921,190.88 |
| **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | **79,052,958,365.40** | **78,182,457,534.69** |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | | **79,052,958,365.40** | **78,184,449,300.32** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

| Үзүүлэлт | Тодруулга | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2 | 1,172,966,765.40 | 1,191,747,109.00 |
| Улсын төвлөрсөн төсвөөс | | - | - |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | - | - |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | | 461,478,165.40 | 151,253,359.00 |
| ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 416,885,277.00 | 108,063,456.00 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 44,592,888.40 | 43,189,903.00 |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | | 711,488,600.00 | 1,040,493,750.00 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | | 711,488,600.00 | 1,040,493,750.00 |
| ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | 54,149,476,970.20 | 22,181,354,056.95 |
| Нийтлэг татварын бус орлого | | 54,149,476,970.20 | 22,181,354,056.95 |
| Төсөв байгууллагын өөрийн орлого | | 203,759,760.00 | - |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | 203,759,760.00 | - |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 52,051,733,708.20 | 21,143,007,332.95 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | 1,893,983,502.00 | 1,038,346,724.00 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 3 | 55,322,443,735.60 | 23,373,101,165.95 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | | 2,223,907,954.22 | 2,642,613,591.10 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 1,954,210,560.52 | 2,449,085,724.57 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 358,403,682.64 | 639,470,252.01 |
| Үндсэн цалин | | 161,809,150.84 | 268,097,672.95 |
| Нэмэгдэл | | 144,560,141.62 | 225,889,302.63 |
| Унаа хоолны хөнгөлөлт | | 21,530,000.00 | 37,480,000.00 |
| Урамшуулал | | 30,504,390.18 | 108,003,276.43 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 46,086,860.16 | 81,826,891.13 |
| Тэтгэврийн даатгал | | 31,500,633.64 | 56,103,980.77 |
| Тэтгэмжийн даатгал | | 3,705,956.38 | 6,534,677.59 |
| ҮОМШӨ-ний даатгал | | 1,816,678.68 | 3,198,038.79 |
| Ажилгүйдлийн даатгал | | 1,816,678.68 | 3,198,038.79 |
| Эрүүл мэндийн даатгал | | 7,246,912.78 | 12,792,155.19 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 26,623,031.92 | 37,691,710.94 |
| Гэрэл, цахилгаан | | 4,335,769.20 | 6,986,733.74 |
| Түлш, халаалт | | 22,287,262.72 | 29,523,149.20 |
| Цэвэр, бохир ус | | | 1,181,828.00 |
| Хангамж, бараа материалын зардал | | 27,174,312.00 | 34,660,023.00 |
| Бичиг хэрэг | | 11,285,500.00 | 3,078,600.00 |
| Тээвэр, шатахуун | | 13,305,176.00 | 6,974,973.00 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 2,583,636.00 | 2,494,450.00 |
| Бараа материал шилжүүлсний зардал | | | 22,112,000.00 |
| Норматив зардал | | - | - |
| Эд хогшил, урсгал засварын зардал | | 5,335,600.00 | 15,312,400.00 |
| Урсгал засвар | | 5,335,600.00 | 15,312,400.00 |
| Томилолт, зочны зардал | | 38,270,000.00 | 34,830,000.00 |
| Дотоод албан томилолт | | 37,730,000.00 | 34,830,000.00 |
| Зочин төлөөлөгч хүлээн авах | | 540,000.00 | - |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 81,888,031.00 | 4,439,016.00 |

| | | | |
|---|---|---|---|
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 81,888,031.00 | 4,439,016.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | | 1,370,429,042.80 | 1,600,855,431.49 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 91,660,200.00 | 165,730,300.00 |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | | 1,278,768,842.80 | 1,435,125,131.49 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 269,697,393.70 | 193,527,866.53 |
| Бусад урсгал шилжүүлэг | | 41,171,387.60 | 3,400,000.00 |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 14,360,000.00 | - |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 26,811,387.60 | 3,400,000.00 |
| Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | | 228,526,006.10 | 190,127,866.53 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | | 168,591,682.74 | 157,070,304.92 |
| Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 59,934,323.36 | 33,057,561.61 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | - | - |
| Дотоод эх үүсвэрээр | | - | - |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **4** | **2,223,907,954.22** | **2,642,613,591.10** |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | | **53,098,535,781.38** | **20,730,487,574.85** |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | | **-** | **-** |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | | **212,339,248.83** | **21,600,988,405.56** |
| **Үндсэн хөрөнгө худалдсаны гарз** | | **212,339,248.83** | **21,600,988,405.56** |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | | **(212,339,248.83)** | **(21,600,988,405.56)** |
| **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | | **52,886,196,532.55** | **(870,500,830.71)** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

| Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,172,966,765.40** | **1,191,947,109.00** |
| ТАТВАРЫН БУС ОРЛОГО | - | 200,000.00 |
| Нийтлэг татварын бус орлого | - | 200,000.00 |
| Бусад орлого | - | 200,000.00 |
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,172,966,765.40 | 1,191,747,109.00 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 461,478,165.40 | 151,253,359.00 |
| ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 416,885,277.00 | 108,063,456.00 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 44,592,888.40 | 43,189,903.00 |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | 711,488,600.00 | 1,040,493,750.00 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 711,488,600.00 | 1,040,493,750.00 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 953,736,065.40 | 1,182,999,709.00 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 684,038,671.70 | 989,471,842.47 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 358,403,682.64 | 643,418,374.38 |
| Үндсэн цалин | 161,809,150.84 | 267,615,395.32 |
| Нэмэгдэл | 144,560,141.62 | 225,889,302.63 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 21,530,000.00 | 37,480,000.00 |
| Урамшуулал | 30,504,390.18 | 108,003,276.43 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 46,106,660.14 | 81,807,091.15 |
| Тэтгэврийн даатгал | 31,500,633.64 | 56,084,180.77 |
| Тэтгэмжийн даатгал | 3,705,956.38 | 6,534,677.59 |
| ҮОМШӨ-ний даатгал | 1,816,678.68 | 3,198,038.79 |

| | | |
|---|---|---|
| Ажилгүйдлийн даатгал | 1,816,678.68 | 3,198,038.79 |
| Эрүүл мэндийн даатгал | 7,266,712.76 | 12,792,155.21 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 26,623,031.92 | 37,691,710.94 |
| Гэрэл, цахилгаан | 4,335,769.20 | 6,986,733.74 |
| Түлш, халаалт | 22,287,262.72 | 29,523,149.20 |
| Цэвэр, бохир ус | - | 1,181,828.00 |
| Хангамж, бараа материалын зардал | 27,283,916.00 | 9,550,850.00 |
| Бичиг хэрэг | 11,049,500.00 | 3,363,600.00 |
| Тээвэр, шатахуун | 13,650,780.00 | 3,692,800.00 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,583,636.00 | 2,494,450.00 |
| Норматив зардал | - | - |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 9,019,050.00 | 15,557,800.00 |
| Багаж, техник, хэрэгсэл | 3,683,450.00 | - |
| Урсгал засвар | 5,335,600.00 | 15,557,800.00 |
| Томилолт, зочны зардал | 38,270,000.00 | 34,830,000.00 |
| Дотоод албан томилолт | 37,730,000.00 | 34,830,000.00 |
| Зочин төлөөлөгч хүлээн авах | 540,000.00 | - |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 84,719,031.00 | 4,439,016.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 84,719,031.00 | 4,439,016.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 93,613,300.00 | 166,607,400.00 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 93,613,300.00 | 166,607,400.00 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 269,697,393.70 | 193,527,866.53 |
| Бусад урсгал шилжүүлэг | 41,171,387.60 | 3,400,000.00 |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 14,360,000.00 | - |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 26,811,387.60 | 3,400,000.00 |
| Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 228,526,006.10 | 190,127,866.53 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 168,591,682.74 | 157,070,304.92 |
| Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 59,934,323.36 | 33,057,561.61 |
| **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **953,736,065.40** | **1,182,999,709.00** |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **219,230,700.00** | **8,947,400.00** |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4) | - | - |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 219,230,700.00 | 8,947,400.00 |
| Дотоод эх үүсвэрээр | 219,230,700.00 | 8,947,400.00 |
| Их засвар | 10,000,000.00 | - |
| Тоног төхөөрөмж | 133,263,700.00 | - |
| Бусад хөрөнгө | 75,967,000.00 | - |
| Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 8,947,400.00 |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -219,230,700.00 | -8,947,400.00 |
| Бусад эх үүсвэр | - | - |
| Санхүүгийн үйл ажиллагааны зардал | - | - |
| САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |

| | | |
|---|---|---|
| НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | - | - |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **-** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **-** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

| Үзүүлэлт | Дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан үр дүн | Нийт дүн |
|---|---|---|---|
| 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 203,921,190.88 | 78,849,037,174.52 | 79,052,958,365.40 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | -870,500,830.71 | -870,500,830.71 |
| 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 203,921,190.88 | 77,978,536,343.81 | 78,182,457,534.69 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Хувь |
|---|---|---|---|---|
| ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,181,266,700.00 | 883,423,445.08 | 297,843,254.92 | 74.8 |
| улсын төсвөөс санхүүжих | - | - | - | |
| ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,181,266,700.00 | 883,423,445.08 | 297,843,254.92 | 74.8 |
| Орон нутгийн төсвөөс | 1,181,266,700.00 | 883,423,445.08 | 297,843,254.92 | 74.8 |
| бусад эх үүсвэр | - | - | - | - |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,181,266,700.00** | **883,423,445.08** | **297,843,254.92** | **74.8** |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 1,231,786,100.00 | 883,423,445.08 | 348,362,654.92 | 71.7 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,211,042,200.00 | 880,023,445.08 | 331,018,754.92 | 72.7 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 651,313,700.00 | 565,090,697.95 | 86,223,002.05 | 86.8 |
| Үндсэн цалин | 284,444,000.00 | 267,615,395.32 | 16,828,604.68 | 94.1 |
| Нэмэгдэл | 290,545,200.00 | 225,889,302.63 | 64,655,897.37 | 77.8 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 47,880,000.00 | 37,480,000.00 | 10,400,000.00 | 78.3 |
| Урамшуулал | 28,444,500.00 | 34,106,000.00 | (5,661,500.00) | 119.9 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 81,414,300.00 | 72,909,931.59 | 8,504,368.41 | 89.6 |
| Тэтгэврийн даатгал | 55,361,700.00 | 50,034,111.94 | 5,327,588.06 | 90.4 |
| Тэтгэмжийн даатгал | 6,513,100.00 | 5,822,904.91 | 690,195.09 | 89.4 |
| ҮОМШӨ-ний даатгал | 3,256,600.00 | 2,842,152.45 | 414,447.55 | 87.3 |
| Ажилгүйдлийн даатгал | 3,256,600.00 | 2,842,152.45 | 414,447.55 | 87.3 |
| Эрүүл мэндийн даатгал | 13,026,300.00 | 11,368,609.84 | 1,657,690.16 | 87.3 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 159,446,300.00 | 26,270,349.54 | 133,175,950.46 | 16.5 |
| Гэрэл, цахилгаан | 49,710,300.00 | 6,986,733.74 | 42,723,566.26 | 14.1 |
| Түлш, халаалт | 33,117,000.00 | 18,101,787.80 | 15,015,212.20 | 54.7 |
| Цэвэр, бохир ус | 26,100,000.00 | 1,181,828.00 | 24,918,172.00 | 4.5 |
| Байрны түрээс | 50,519,000.00 | - | 50,519,000.00 | - |
| Хангамж, бараа материалын зардал | 19,644,800.00 | 7,470,850.00 | 12,173,950.00 | 38.0 |
| Бичиг хэрэг | 8,000,000.00 | 1,776,400.00 | 6,223,600.00 | 22.2 |
| Тээвэр, шатахуун | 6,645,600.00 | 3,200,000.00 | 3,445,600.00 | 48.2 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,999,200.00 | 2,494,450.00 | 2,504,750.00 | 49.9 |
| Норматив зардал | - | - | - | |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 72,571,800.00 | 24,505,200.00 | 48,066,600.00 | 33.8 |
| Багаж, техник, хэрэгсэл | 15,000,000.00 | 4,557,900.00 | 10,442,100.00 | 30.4 |
| Урсгал засвар | 57,571,800.00 | 19,947,300.00 | 37,624,500.00 | 34.7 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Томилолт, зочны зардал | 39,164,800.00 | 29,430,000.00 | 9,734,800.00 | 75.1 |
| Дотоод албан томилолт | 39,164,800.00 | 29,430,000.00 | 9,734,800.00 | 75.1 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 36,964,000.00 | 4,439,016.00 | 32,524,984.00 | 12.0 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 36,964,000.00 | 4,439,016.00 | 32,524,984.00 | 12.0 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 150,522,500.00 | 149,907,400.00 | 615,100.00 | 99.6 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 150,522,500.00 | 149,907,400.00 | 615,100.00 | 99.6 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 20,743,900.00 | 3,400,000.00 | 17,343,900.00 | 16.4 |
| Бусад урсгал шилжүүлэг | 20,743,900.00 | 3,400,000.00 | 17,343,900.00 | 16.4 |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 12,293,900.00 | - | 12,293,900.00 | |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,450,000.00 | 3,400,000.00 | 5,050,000.00 | 40.2 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | - | - | |
| Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | - | - | |
| **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | **1,231,786,100.00** | **883,423,445.08** | **348,362,654.92** | **71.7** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **-** | **-** | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **-** | **-** | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн |
|---|---|---|---|
| ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 151,253,359.00 | -151,253,359.00 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | | 151,253,359.00 | -151,253,359.00 |
| ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 108,063,456.00 | -108,063,456.00 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 43,189,903.00 | -43,189,903.00 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | | 151,253,359.00 | -151,253,359.00 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | | 151,253,359.00 | -151,253,359.00 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 118,195,797.39 | -118,195,797.39 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 73,897,276.43 | -73,897,276.43 |
| Үндсэн цалин | | - | - |
| Урамшуулал | | 73,897,276.43 | -73,897,276.43 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 8,897,159.56 | -8,897,159.56 |
| Тэтгэврийн даатгал | | 6,050,068.83 | -6,050,068.83 |
| Тэтгэмжийн даатгал | | 711,772.68 | -711,772.68 |
| ҮОМШӨ-ний даатгал | | 355,886.34 | -355,886.34 |
| Ажилгүйдлийн даатгал | | 355,886.34 | -355,886.34 |
| Эрүүл мэндийн даатгал | | 1,423,545.37 | -1,423,545.37 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 11,421,361.40 | -11,421,361.40 |
| Түлш, халаалт | | 11,421,361.40 | -11,421,361.40 |
| Хангамж, бараа материалын зардал | | 1,880,000.00 | -1,880,000.00 |
| Бичиг хэрэг | | 1,387,200.00 | -1,387,200.00 |
| Тээвэр, шатахуун | | 492,800.00 | -492,800.00 |
| Норматив зардал | | - | - |
| Эд хогшил, урсгал засварын зардал | | - | - |
| Томилолт, зочны зардал | | 5,400,000.00 | -5,400,000.00 |
| Дотоод албан томилолт | | 5,400,000.00 | -5,400,000.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | - | - |
| Бараа үйлчилгээний бусад зардал | | 16,700,000.00 | -16,700,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 16,700,000.00 | -16,700,000.00 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 33,057,561.61 | -33,057,561.61 |
| Бусад урсгал шилжүүлэг | | - | - |
| Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох | | 33,057,561.61 | -33,057,561.61 |
| Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 33,057,561.61 | -33,057,561.61 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | - | - |
| НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | | 151,253,359.00 | -151,253,359.00 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | - | - |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | - | - |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 424,229.0 мянган төгрөгийн 5 алдаа[1] илэрснээс аудитын явцад 424,229.0 мянган төгрөгийн 5 алдааг залруулсан. Үүнд:

- Санхүүгийн тайланг хүчингүй болсон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу бэлтгэж тайлагнасан,
- Тайлант онд үнэ төлбөргүй шилжүүлсэн 22,112.0 мянган төгрөгийн бараа материалыг бараа үйлчилгээний бусад зардалд бүртгэн тайлагнасан,
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн цалингийн зардлын дүнг цалингийн баталгаажсан цэстэй тулган баталгаажуулахад 5,433.2 мянган төгрөгийн илүү тайлагнасан
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын дүнг тодруулга тайлангийн уг дүнтэй тулган баталгаажуулахад 394,892.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан
- Өглөгийн тодруулга тайлангийн ХХОАТ-ын өглөгийн хөндлөнгийн тулган баталгаажуулалттай тулган шалгахад 1,791.8 мянган төгрөгийн өглөг дутуу бүртгэж тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "*үнэн зөв байх*" 20 дугаар зүйлийн 20.2-д "*Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ*", 20.2.3-д "*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*", болон санхүүгийн тайлангийн толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 107,410.0 мянган төгрөгийн 2 зөрчил[2] илэрснээс хууль хэрэгжүүлэхтэй холбоотой 1 албан шаардлага, 1 төлбөрийн акт тогтоосон.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 85,171.0 мянган төгрөгөөр их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

---

[1] *Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,*
*1 Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.*

*2 Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.*

**3.1 Төлбөрийн акт**

***Илрүүлэлт:*** Албан томилолтоор ажилласан албан хаагчдад 1,910.0 мянган төгрөгийн хоолны нөхөх төлбөрийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "*хариуцлагатай байх*", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*", 16.5.5-д "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "*үнэн зөв байх*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**3.2 Албан шаардлага**

***Илрүүлэлт:*** Тайланд онд сургалт зохион байгуулахдаа 105,500.0 мянган төгрөгийг цай, хоол, буудлын төлбөрт зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "*хариуцлагатай байх*", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*", 16.5.5-д "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д "*Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана*" 15.2.7-д "*сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**3.3 Зөвлөмж**

***Илрүүлэлт:*** Шилэн дансны нэгдсэн системд аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, Байгууллагын батлагдсан төсөв, Дараа жилийн төсвийн төслийн мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай, үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн хэрэгжилтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт заасан 2026 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Албан томилолтоор ажилласан албан хаагчдад 1,910.0 мянган төгрөгийн хоолны нөхөх төлбөрийг давхардуулан олгосон | 1 | 1,910.0 | 1 | 1,910.0 | | | | | | | | |
| Тайланд онд сургалт зохион байгуулахдаа 105,500.0 мянган төгрөгийг цай, хоол, буудлын төлбөрт зарцуулсан | 1 | 105,500.0 | | | 1 | 105,500.0 | | | | | | |
| Дүн | **2** | **107,410.0** | **1** | **1,910.0** | **1** | **105,500.0** | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланг бэлтгэхдээ хүчингүй болсон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу бэлтгэсэн | 1 | - | | | 1 | - | 1 | - | | | | |
| Тайлант онд үнэ төлбөргүй шилжүүлсэн 22,112.0 мянган төгрөгийн бараа материалыг бараа үйлчилгээний бусад зардалд бүртгэн тайлагнасан | 1 | 22,112.0 | 1 | 22,112.0 | | | 1 | 22,112.0 | | | | |
| Санхүүгийн үр дүнгийн тайлангийн цалингийн зардлын дүнг цалингийн баталгаажсан цэстэй тулган баталгаажуулахад 5,433.2 мянган төгрөгийн илүү тайлагнасан | 1 | 5,433.2 | 1 | 5,433.2 | | | 1 | 5,433.2 | | | | |
| Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын дүнг тодруулга тайлангийн уг дүнтэй тулган баталгаажуулахад 394,892.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан | 1 | 394,892.0 | 1 | 394,892.0 | | | 1 | 394,892.0 | | | | |
| Өглөгийн тодруулга тайлангийн ХХОАТ-ын өглөгийн хөндлөнгийн тулган баталгаажуулалттай тулган шалгахад 1,791.8 мянган төгрөгийн өглөг дутуу бүртгэж тайлагнасан | 1 | 1,791.8 | 1 | 1,791.8 | | | 1 | 1,791.8 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дүн | **5** | **424,229.0** | **4** | **424,229.0** | **1** | | **5** | **424,229.0** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ***Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой*** | | | | | | | | |
| Шилэн дансны нэгдсэн системд аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, Байгууллагын батлагдсан төсөв, Дараа жилийн төсвийн төслийн мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан. | 1 | - | | | | | 1 | - |
| Дүн | **1** | **-** | | | | | **1** | **-** |